

## НИЙТЛЭЛ

## Монгол Улсын гадаад бодлогын шинэчлэл

Дашдоржийн Баярхүү 

Гадаад бодлогын эксперт, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд  
Улаанбаатар, Монгол Улс  
[bayardevi@hotmail.com](mailto:bayardevi@hotmail.com)

**Хураангуй:** Монгол Улсын гадаад бодлого ардчилал, шинэчлэлийн 33 жилд хэрхэн хувьсан өөрчлөгдсөн, ямар үр дүнд хүрсэн тухай түүхэн сэдвийг 6 Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны дэвсгэр дээр хөндлөө. Манай үе үеийн Ерөнхийлөгч, Засгийн газрууд залгамж чанараа хадгалсан, бие даасан, тэнцвэртэй, идэвхтэй, нээлттэй, олон тулгуурт, онолын хувьд прагматик гадаад бодлого явуулж иржээ. СССР-ын үед БНМАУ бол хэрэг дээрээ Зөвлөлтийн 16 дахь холбооны БНУ мэт дагуул улсын зовлонг туулсан. “Хүйтэн дайн” дууссаны дараа шинэ Монгол Улс шинэ гадаад бодлогоо эрэлхийлсэн, тунхагласан, улмаар Хятад болон империалист гэгдсэн Америк, Япон, Өрнөд Европ зэрэг олон шинэ түнш-орон руу хандсан “олон тулгуурт” гадаад бодлого руугаа шилжсэн. Ердөө жил, жил хагасын дараа гэхэд бүрэн эзэн мэдсэн, тусгаар тогтнолоо бэхжүүлсэн олон тулгуурт гадаад бодлогыг сонгон авч хэрэгжүүлсээр өнөө хүрчээ. Энэ тухай үечлэн, багцлан дор бичсэн болно.

**Түлхүүр үгс:** Олон тулгуурт гадаад бодлоготой Монгол, 6 Ерөнхийлөгчийн 6 гадаад бодлого, хоёр хөрш ба гуравдагч хөрш, Иж бүрэн стратегийн түншилэл ба Стратегийн түншилэл.

## Нэг. Гадаад бодлогын шилжилт (1990-ээд он)

1990-1992 он хүртэл БНМАУ нь дэлхийн социалист хамтын нөхөрлөлийн гишүүн, коммунист намаар (МАХН) удирдуулсан социалист байгуулалтай улс байв. Зөвлөл Холбоот Улсын үед Монгол бол хэрэг дээрээ Зөвлөлтийн 16 дахь холбооны БНУ гэгдэж байсан

ба “Хүйтэн дайн” дууссаны дараа өнөөгийн Орос нь СССР-ийн үеийнх шиг Монголтой тогтоосон харилцаагаа чухалчлах арга ухаанаа олоогүй, тэр хэрээрээ биднийгээ “хөсөр хаясан”. “Хөсөр хаягдсан” шинэ Монгол Улсын шинэ гадаад бодлого аргагүйн эрхэнд



Хятад, Америк, Япон зэрэг олон шинэ түнш-орон руу хандсан “олон тулгуурт” гадаад бодлого руу шилжихэд анхны Ерөнхийлөгч П.Очирбат, анхны ардчилсан эвслийн Засгийн газар, Ерөнхий сайд Д.Бямбасүрэн, П.Жасрай, анхны Улсын Бага Хурал, анхны УИХ түүхэн үүрэг гүйцэтгэсэн билээ.

Манай улс түүхэндээ анх удаа 1994 оноос Үндэсний аюулгүй байдлын болон Гадаад бодлогын үзэл баримтлалуудаа боловсруулж, хуульчлан, дагаж мөрдсөн. Тэрхүү үзэл баримтлалуудыг 1996 онд УИХ-ын хоёр дахь сонгуулиар байгуулагдсан Ардчилсан хүчний Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөр анх удаа тодотгон хэрэгжүүлсэн. Дараа дараагийн шинэ УИХ-уудын үед тэгдэг уламжлал хэвшүүлж чадсан. Улс төрийн ямар ч нам засгийн эрх барьлаа гэхэд Үзэл баримтлалын дагуу зохиогдсон мөрийн хөтөлбөртэй, тэр нь улс үндэснийхээ эрх ашгийг дээдэлсэн, гадаад таатай уур амьсгал бүрдүүлэх, гадаад хамтын ажиллагаа хөгжүүлэхэд чиглэсээр өнөө хүрчээ.

Тэр үеийн Монгол Улсын гадаад бодлогын гол онцлог гэвэл дараах байдлаар жагсааж болно. Үндэсний ашиг сонирхлоо дээдлэх; хөрш хоёр оронтойгоо тэнцвэртэй харилцах; гадаад харилцаагаа өргөтгөн олон түнштэй болох; гуравдагч хөршийн бодлого явуулах; бүс нутгийн интеграцид оролцож, түүнд өөрийн орон зайтай болох; олон улсын хамтын хүчин чармайлтыг чадал чинээнийхээ хэрээр дэмжихийг чиг баримжаагаа болгох; энэ бүгдээ Үндэсний аюулгүй байдлын болон Гадаад бодлогын үзэл баримтлалууддаа тусгаж мөрдөх явдал

байсан билээ.

1990-ээд оны нэг гол онцлог бол гадаад харилцааны салбарт хоёр талын түүхэн айлчлалууд анх удаа хэрэгжиж, цоо шинээр маш олон түншүүдтэй болсон явдал юм.

1990-ээд оны үед аюулгүй байдлын хувьд өмнө нь хэрэгжүүлж байгаагүй, тэр талын туршлагагүй ч цоо шинэ бодлогоо дэвшүүлснийг энд дурдах ёстой. Юу гэвэл Монгол Улс нь хүчирхэг нэг гүрний (СССР) ивээлд байж, бодлогыг нь дагах замаар бус, харин бүх улс оронтой найрсаг харилцаа хөгжүүлж, гадаад аюулгүй байдлаа давын өмнө идэвхтэй гадаад бодлого явуулах, улс төр, дипломатын аргаар ханган бэхжүүлэх, өөрийн аюулгүй байдлыг бүс нутгийн аюулгүй байдалтай нягт холбох чиглэл баримтлах болжээ.

Цөмийн зэвсэгтэй хоёр гүрний дунд оршдогийнхоо хувьд 1992 оноос өөрийн нь язгуур ашиг сонирхлыг шууд хөндөөгүй тохиолдолд тэдний маргаанд үл оролцох, боломжийн хэрээр төвийг сахих, нутаг дэвсгэрээ бусад улс орон, түүний дотор хөрш орныхоо аюулгүй байдлын эсрэг ашиглуулахгүй байх чиг шугам баримталсан нь тухайн үедээ маш том зориг зүрх гаргасан адбиш алхам байв. СССР-ийг залгамжлагч ОХУ нь 1992 онд багтааж Монгол дахь цэргийнхээ баазуудаа татан буулгаж, цэрэг, зэвсэг техник, мөн мэргэжилтнээ гаргаснаар бид улс орныхоо язгуур ашиг сонирхолд нийцсэн бодлого явуулах бодит боломжийг анх удаа өөртөө нээсэн. Өөрөөр хэлбэл 1921 онд тусгаар тогтнолоо эгнэгт олж авснаас хойш 70 гаран жилийн туршид анх удаа бие дааж гадагш ажиллах, бие даан өөрийн ухаан сэтгэлгээгээр гадаад бодлого явуулах

алтан боломж бүрдсэн юм.

Тэрхүү боломжийг ашиглан цоошинэ гадаад бодлогынхоо хүрээнд 1992 онд Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 47 дугаар чуулганы ерөнхий санал шүүмжлэлд оролцож үг хэлэхдээ Монгол Улс нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс болгож буйг албан ёсоор зарлан тунхагласан билээ. Тэрээр хэлсэн үгэндээ “Монгол Улс зэвсэг хураах хийгээд бүс нутаг, дэлхий дахинд итгэлцлийг бэхжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулах үүднээс

өөрийн нутаг дэвсгэрийг цөмийн зэвсэггүй бүс хэмээн зарлан тунхаглаж байна. Үүнийгээ цаашид олон улсын хэмжээнд баталгаажуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг эрмэлзэх болно”<sup>1</sup> хэмээн цохон тэмдэглэсэн байдаг. Мөн цаашид Төв Азийг цөмийн зэвсэггүй бүс болгохын ач холбогдлыг харгалзан Монгол Улс тэрхүү бүсийг “цөмийн зэвсгээр хөөцөлдөх, түүнийг турших талбар болгохгүйн төлөө байгаагаар”<sup>2</sup> тэрээр онцлон тэмдэглэжээ.

### **Хоёр. Гадаад бодлогын шилжилт ба шинэчлэл (2000-аад оны эхэн үе)**

Шинэ зуунд гадаад бодлогын нэгдмэл чанарыг ханган олон улсын харилцаанд нэн идэвхтэй гадаад бодлого хэрэгжүүлж чадсан. 2000 онд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Монгол Улсад айлчилж, хоёр тал “Улаанбаатарын тунхаглал”-д гарын үсэг зурсан нь хоёр орны харилцааг шинэ зуунд идэвхтэй хөгжүүлэх үндсийг тавьснаас гадна түүхнээ 1974 оноос хойш анх удаа хойд хөршийн төрийн тэргүүн Монголд айлчилснаараа онцлог байв.

Шинэ зуунд олон улсын терроризмын эсрэг тэмцэл өрнөхөд Монгол Улс гярхай тусган авч, тэр тэмцэлд оролцохоор цэрэг армия бэлтгэж, энхийг сахиулах үйлсэд хувь нэмрээ өргөсөн нь гадаад бодлогын шинэлэг, зарчмын анхны томхон алхам байлаа. Н.Багабандийн үед олон талт дипломатын бодлогод нэг том дэвшил гарсан нь 2002 онд Монгол Улс

Азид хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх дээд хэмжээний уулзалтад (Алма-Аты) анх удаа оролцож, гишүүнээр элсэж, 2003 онд Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын ажиглагч гишүүний статустай болжээ<sup>3</sup>.

Ач холбогдол бүхий хоёр талын олон айлчлалуудаас гадна Монгол Улс дэлхий дахины томхон форумыг эх орондоо зохион байгуулж эхэлсэн. 2003 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын V бага хурал Н.Багабанди, Н.Энхбаяр нарын гадаад бодлогын амжилтын оргил нь байлаа. Энэ бага хурал “Ардчилал, сайн засаглал, иргэний нийгэм” гэсэн сэдвийн дор явагдаж, дэлхийн 119 улс орны төлөөлөгчид оролцсон. Ардчиллыг төлөвшүүлэх чиглэлээр олон улсын хамтын нийгэмлэгээс цаашид явуулах үйл

<sup>1</sup> Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалын 20 жил, Эрдэм шинжилгээний бага хурлын материал, ГХЯ, 2014

<sup>2</sup> Мөн тэнд

<sup>3</sup> Монгол Улсын Гадаад бодлогын хөх ном-2006, ГХЯ

ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон хоёр чухал баримт бичиг–Улаанбаатарын Тунхаглал, Үйл ажиллагааны хөтөлбөрийг батлан гаргасан<sup>4</sup>. Энэ бага хурлын өмнөх өдөр нь Олон улсын иргэний нийгмийн чуулга уулзалт Улаанбаатарт хуралдаж байсан түүх буй.

Эрх зүйт төртэй ардчилсан улсын гадаад бодлогод гэнэтийн хувиралт, огцом эргэлт гардаггүй, гарч болохгүй, харин ч түүнийгээ цааш нь төгөлдөржүүлэн, солонгоруулан үргэлжлүүлдэг гэдгийг ноён Н.Багабанди, Н.Энхбаяр нар нотолж ажилласан. 2005 оноос ШХАБ-ын дээд хэмжээний уулзалтад оролцдог болж, 2008 онд Бээжинд Ази-Европын уулзалтад (АСЕМ) уригдаж гишүүн нь болсноос хойш Төрийн тэргүүний түвшинд оролцож иржээ.

Ноён Н.Энхбаяр 2005 онд Астана хотноо, 2006 онд Шанхай хотноо ШХАБ-ын дээд хэмжээний уулзалт, 2005 онд Ерөнхий сайд Ц.Элбэгдорж Москва хотноо ШХАБ-ын гишүүн орнуудын Засгийн газрын тэргүүн нарын зөвлөлийн хуралд ажиглагчаар оролцсон. Ийнхүү оролцохдоо Монгол Улс нь бүс нутгийн хамтын ажиллагаанд жинтэй байр суурьтай энэ байгууллагын үйл ажиллагаанд ач холбогдол өгнө, гэхдээ ажиглагчийнхаа давуу статусаа ашиглана гэдгээ ч ШХАБ-ын гишүүн орнуудад тов тодорхой ойлгуулсан гэж үзэж болно.

Н.Энхбаярыг төр толгойлж байх үеийн (Ерөнхий сайд нь Ц.Элбэгдорж)

гадаад бодлогын нэг чухал ололт бол түүхнээ анх удаа АНУ-ын Ерөнхийлөгч манай улсад айлчилсан явдал юм. 2004 онд ноён Н.Энхбаяр АНУ-д айлчилж, хоёр орон нийтлэг ардчиллын үнэлэмж хийгээд нийтлэг стратегийн ашиг сонирхолд үндэслэсэн бүх талын түншлэлийн харилцаа тогтоосон. 2005 онд Ерөнхийлөгч Ж.Буш Монголд хариу айлчилжээ. “Мянганы сорилын сан”-гийн тусламж, Монгол-Америкийн батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа гэх мэт түүхэнд тэмдэглэгдэх алхмууд тэр үеэс яригдана.

Ерөнхийлөгч Н.Энхбаяр хоёр хөршийн талаар ч ухаалаг бодлого явуулсан. Тэрээр 2006 онд Орост айлчилж, хоёр тал “Москвигийн тунхаглал”-д зурсан бөгөөд Монгол-Оросын харилцаа эндээс эхлэн бүх талаар идэвхжих үе рүүгээ орсон юм. Дараа нь Оросын Ерөнхий сайд болон Ерөнхийлөгч нар дараалан Монголд айлчилсан ба Монгол нь Оросын гадаад бодлогын зах хязгаараас дахин гадаад бодлогын төвд орсныг харуулжээ. Монгол-Хятадын харилцааны хувьд Н.Энхбаярын үед тэргүүлэх чиглэлээ алдаагүй.

Энэ хугацаанд Монголд төр, засаг олон удаа солигдсон. Засгийн газруудын үйл ажиллагааны салбаруудаас (гадаад харилцаа, батлан хамгаалах, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, хууль цааз, байгаль орчин гэх мэт жагсана) ганцхан гадаад харилцааны салбар л ямагт прогрессоор урагшилж, ямагт нэмэх үзүүлэлттэй гарч ирсэн байх юм.

<sup>4</sup> [www.parliament.mn/files/download/119717](http://www.parliament.mn/files/download/119717)

**Гурав. Гадаад бодлогын шилжилт ба шинэчлэл (2009-2017 он)**

Мэдээж нэгэнтээ хэвшээд тогтчихсон, зөв төлөвшчихсэн гадаад бодлогыг үргэлжлүүлэхээр 2009 онд эрхэм Ц.Элбэгдорж сонгогдсон, тэр хэрээрээ ч 8 жил эргэлт буцалтгүй ажилласан. Ерөнхийлөгч гэх тэр институцын цоо шинэ имижийг бүрдүүлж чадсан. Гадаад бодлогыг 8 жил тасралтгүй явуулсан. ҮАБЗ-ийн тэргүүнийхээ хувьд, уг зөвлөлийн хоёр гишүүн УИХ-ын дарга, Ерөнхий сайд нарт үлгэр болоод тэр гадаад бодлогоо хэрэгжүүлж болдог юм аа гэдгийг харуулсан.

Аль ч Ерөнхийлөгчийн үед, аль ч УИХ, Засгийн газрын үед Монголын гадаад бодлогын залгамж чанар хадгалагдаж, харилцаа өргөжин тэлж ирсэн бөгөөд тэгэхдээ прогрессоор, тоо чанарынхувьд ямагт өсөж дэвжиж ирсэн, гэхдээ Ерөнхийлөгч өөрөө санаачилбал, араас нь хөөцөлдвөл гадаад бодлого дээр дэлгэрүүлж хэрэгжүүлэх олон үйлс байдаг юм гэдгийг Ц.Элбэгдоржийн 8 жилийн түүх, өнөөгийн Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн ажилласан хоёр жилийн түүх нотлон харуулж байна. Шинэ зууны шинэ нөхцөл байдалд тохируулан 1994 онд баталсан Гадаад бодлогын үзэл баримтлал (2011 он), Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаа (2010 он) шинэчлэн баталж мөрдөж байна. Ийнхүү шинэчлэх болсон тухай үндэслэлээ дараах байдлаар тайлбарласан. Үүнд:

XXI зуун гарсаар дэлхий дахинд даяаршил улам бүр тэлж, шинжлэх ухаан, мэдээллийн технологи үсрэнгүй

хөгжин, улс төр, эдийн засгийн интеграци өргөжиж, улс хоорондын харилцан хамаарал гүнзгийрч байна. Олон улсын харилцаа өнгөрсөн зууны сүүлийн хагасын хоёр туйлт үеийнхээс эрс өөрчлөгдлөө. Хөгжлийн шинэ томоохон төвүүд тодорч, олон улсын харилцаанд тэдгээрийн үзүүлэх нөлөө өсөх хандлагатай байна. Нөгөөтээгүүр, улс орнуудын хөгжлийн хурд, түвшин улам бүр ялгарч, буурай, эмзэг эдийн засагтай улсуудад ажилгүйдэл, ядуурал буурахгүй байна. Зарим улс, бүс нутагт цөмийн зэвсэгтэй болох оролдлого үргэлжилж, хурцадмал байдал намжихгүй байна. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол хийгээд олон улсын терроризм, хүний болон хар тамхины наймаа, гоц халдварт өвчний тархалт зэрэг аюул, сорилт нэмэгдэх болов. Монгол Улс ардчилсан ёс, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, зах зээлийн эдийн засаг бүхий улс болж хөгжихийн хамт гадаад харилцаа, хамтын ажиллагаа улам бүр өргөжин тэлж, гадаадад ажиллаж, сурч байгаа иргэдийн тоо үлэмж нэмэгдэв. Монгол Улс нөөц баялгаа ашиглан эдийн засгийн чадавхыг өсгөх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, хүн амын амьжиргааг дээшлүүлэх эрчимтэй хөгжлийн замд орж байна. Дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд Монгол Улсын оруулж ирсэн хувь нэмрийг улам өсгөх, үндэсний хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд гадаад харилцааг өргөтгөн хөгжүүлж, түүний үр

өгөөжийг улам нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна<sup>5</sup> гэжээ.

Олон улсын харилцаанд Монголын жинг нэмэх юмсан, энэ жинг нэмж үлдээх юмсан гэсэн чин хүсэл эрмэлзэлтэй<sup>6</sup> хэмээн Ц.Элбэгдорж өөрөө нэг удаа ярьсан байдаг. Тэр угтаар гадаад бодлого огцом идэвхэжсэн, шинэ агуулгаар баяжсан, тэр тоолонд тэр жин нь нэмэгдсэн.

Монгол, Орос, Хятадын гурвалсан дээд түвшний уулзалтыг том амжилт хэмээн нэрлэж болно. 2014 онд ердөө 5 хүрэхгүй сарын дотор болж өнгөрсөн үйл явдлыг эргэж санууля. Монгол Улсын Ерөнхийлөгч өөрөө энэ асуудлыг анхлан 2014 оны 4 дүгээр сард санаачлан ҮАБЗ-д хэлэлцүүлж дэмжүүлээд 5 дугаар сарын 20-21-нд Шанхайд Азид хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх бага хурлын дээд хэмжээний уулзалтын үеэр нөгөө хоёр улсынхаа төрийн тэргүүнд тавьж, хоёуланг нь урьж, урьсны дагуух айлчлалыг тэр зун намрын зааг үед амжилттай зохион байгуулж, залгаад Тажикистаны нийслэлд хоёр гүрний удирдагчийг гурван талын уулзалтад урин нийтлэг асуудлаа ярилцсан билээ. Дэлхийн бодлогыг тодорхойлолцдог, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын 5 гишүүний хоёр нь болох хоёр том гүрний удирдагчдыг ийм богино хугацаанд, бараг зэрэг шахуу айлчлуулаад, дараа нь тийм богино хугацаанд гурван талын дээд хэмжээний уулзалтад уриад, тэр уулзалтаа амжилттай хэрэгжүүлсэн, залгуулаад 2015 онд Уфад, 2016 онд Ташкентад үргэлжлүүлсэн, ийм дипломатын уламжлалыг хэвшүүлсэн

ноён Ц.Элбэгдорж Монголын түүхнээ, тэр дундаа гадаад бодлогын түүхнээ нэрээ мөнхжүүлсэн болов уу.

Олон талт хамтын ажиллагааны чиглэлд Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн үед жинхэнэ “их цөмрөлт” хийж чадсан. АСЕМ-ын Дээд түвшний XI уулзалтыг нэрлэе. Азидаа 6 дахь дээд хэмжээний уулзалтын зочин улсаар Монгол, зочин хотоор Улаанбаатар хот тодорсон. АСЕМ-ын дээд хэмжээний анхны уулзалт Азид болж, түүчээлсээр 6 дахь нь Улаанбаатарт болж таарсан. “Хельсинкийн төгсгөлийн баримт бичиг”, “Киотогийн протокол” гэдэг шиг “Улаанбаатарын тунхаглал” гэх баримт бичиг дэлхийд нэрлэгдэж явна. АСЕМ-ын 20 жилийн ойг тэмдэглэх хүрээнд түүний үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, АСЕМ-аас гурав дахь 10 жилдээ баримтлах үндсэн чиг шугамыг тодорхойлсноороо тунхаглалын гол утга илэрхийлэгдэнэ. “Нэгэн зуунд дахин тохиохгүй” гэсэн санаагаар ноён Ерөнхийлөгч өөрөө XI уулзалтыг нэрлэсэн. Нийт 51 гишүүнтэй, 51 улсад нь ээлжлээд Ази, Европын гэж солбиод хоёр жилд нэг удаа чуулдаг гэвэл АСЕМ-ын дараагийн уулзалт Монголд иртлээ лав 100 жилийн зай байна гэсэн санаа юм. Монголын түүхнээ ийм үйл явдал өмнө нь тохиож байгаагүй, хойшдоо, нэг хэсэгтээ огт тохиохгүй гэдгийг хэлж байна. Хоёр тивийн ийм олон улсын удирдагчид нэгэн зэрэг манай эх орны нийслэлд цуглараад, чуулаад, Монгол орон, монголчуудын үнэн түүх, нүүр царай, соёл урлаг, хөгжил дэвшлийг нэгэн зэрэг мэдрээд, үнэлээд буцна гэдэг үгээр хэлж төсөөлж боломгүй түүхэн

<sup>5</sup> [mfa.gov.mn/documentation/55645](http://mfa.gov.mn/documentation/55645)

<sup>6</sup> 2014 он - Монголын Цахиагийн Элбэгдорж, [mongolyin-tsakhiagiin-elbegdorj.org/uploads/files/](http://mongolyin-tsakhiagiin-elbegdorj.org/uploads/files/)

үйл явдал билээ.

Ноён Ц.Элбэгдорж түүхэнд анх удаа АПЕК-ийн эдийн засгийн лидерүүдийн уулзалтад 2014 онд уригдаж оролцсон. Улмаар Азид хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх бага хурлын дээд хэмжээний 4 дэх удаагийн уулзалт, ШХАБ-ын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн 5 удаагийн хуралдаанд уригдан оролцсон. АСЕАН-ы яриа хэлэлцээний түнш, Зүүн Азийн дээд түвшний уулзалтын оролцогч орон болох зорилтыг хангах чиглэлд идэвхтэй ажилласан. Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа хэлэлцээ”-г Ерөнхийлөгч санаачлаад, тэр хүрээнд олон улсын эрдэм шинжилгээний гурван ч бага хурал Улаанбаатартаа зохион байгуулжээ. “Азийн форум” санаачилга дэвшүүлэв. НҮБ, “77”-гийн бүлэг, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн зэрэг олон талын хүрээнд хамтран ажиллах, хөгжиж буй орнуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэх зорилт хэрэгжив.

2012 онд “P5” буюу НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын 5 гишүүн улс хамтарсан тунхаглал гаргаж Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх бодлогыг хүндэтгэхээ манай улсад, цаашилбал өөр өөрсдөдөө амласан нь итгэлцлийг бэхжүүлсэн чухал үйл явдал болсон төдийгүй, хойшид энэхүү статусаа цаашид баталгаажуулж олон улсын хэмжээнд бүгд хүлээн зөвшөөрсөн дэглэм (regime)-тэй болохыг зорьж ажиллах үндсийг тавьсан дипломатын томхон алхам болсон билээ.

2015 онд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн гишүүнээр манай бүс нутгийн бүлгээсээ хамгийн их саналаар анх удаа сонгогдсон, Монгол Улс НҮБ-

ын энхийг сахиулах ажиллагаанд харьцангуй сүүлд хамрагдсан улс боловч НҮБ-д цэнхэр дуулгатнаа хандивладаг НҮБ-ын гишүүн топ 20 улсын нэг болж чадсан, ардчилал, хүний эрхийг дээдлэх, сайн засаглал төлөвшүүлэх, авлигатай тэмцэх талаар Азидаа нэр хүндтэй улс болж, тэр утгаар өөрийн орны туршлагыг ардчиллыг шинээр болон сэргээн хөгжүүлэхээр зорьж байгаа улс орнуудтай хуваалцан хамтран ажиллах зорилгын үүднээс “Олон улсын хамтын ажиллагааны сан” байгуулж, Киргиз, Мьянмар, Афганистан, БНАСАУ, Лаос, Камбож, Балба, Бутан, Шри-Ланка, Зүүн Тимор зэрэг улстай сайн засаглал, ардчиллын туршлагаа хуваалцаж буй, Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэг, “Онлайн эрх чөлөө” эвслийг тус тус амжилттай даргалсан.

Олон тулгуурт гадаад бодлогынхоо тэнцвэрийг хангах талаар ч гарамгай сайн ажиллаж чадсан. НҮБ-ын бүх гишүүн орнуудтай дипломат харилцаа тогтоох санаачилгыг Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж бүрэн эрхийнхээ эхний жилүүдэд Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 100 жилийг ойг угтуулж дэвшүүлсэн. Уг зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улстай дипломат харилцаа тогтоосон орны тоо 193 хүрээд байна. 2012 оны эхэнд дипломат харилцаа тогтоосон орны тоо 149 байсантай харьцуулахад том дэвшил гарчээ. Нээлттэй гадаад бодлогын хүрээнд дипломат харилцаатай улсын тоог нэмснээр манай улсын гадаад харилцаа улам өргөжин тэлж дэлхийн аль ч өнцөг буланд хүрэх нь мэдээж.

Гадаад бодлогын тэнцвэрийг хангах талаар Монгол-Орос-Хятадын гурвалсан харилцаанаас цааш ололт

амжилт олныг хэрэгжүүлж чадсан. АНУ, Япон, Европын Холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “туравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх тухай Гадаад бодлогын үзэл баримтлалын зорилт хэрэгжсээр байна. Айлчлалууд хоёр урсгалтай болсон. Монгол, Японы стратегийн түншлэл бэхэжсэн, Монгол улсын хувьд анхны чөлөөт худалдааны хэлэлцээр-Монгол, Японы Эдийн

засгийн түншлэлийн хэлэлцээр хүчин төгөлдөр боллоо. Азийн бусад улстай хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутагт олон талт хамтын ажиллагаанд оролцох, Зүүн Ази, Зүүн хойд Ази, Төв Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг дэмжиж оролцох бодлого нэгэнтээ хэвшиж хөгжиж байна.

### **Дөрөв. Гадаад бодлогын шилжилт ба шинэчлэл (2017-2021 он)**

Монгол Улсын 5 дахь Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Төрийн гадаад бодлогын залгамж чанарыг алдалгүй хадгалж ирсэн билээ. Гадаад харилцааны асар өргөн фронтыг ноён Х.Баттулга шүүмжлэлт өнцгөөс харсан. Аль нь хэрэгтэй, хэрэггүй юм гэдгийг ялгаж салгахыг хичээсэн. Үрэлгэн, хөл хөөрцөг болсон гадаад айлчлалуудаас татгалзсан. Олон талт форумыг хоёр талын харилцаанд ашиглаж болно гэдэг дээр чармайлт гаргасан. Дипломат албыг ч өөрөөр харахыг хичээсэн. “Монголын ард түмэнд яг биетэй бодитой ашигтай ямар ажил хийж байна вэ Та нар?” гэх хатуу асуулт дипломатчидад тулгаж тавьсан. Дипломат алба бол тэгтлээ хошуурдаг, үхэлддэг, шагнал шахааны алба, албан тушаал биш гэдгийг ч хэд хэдэн удаа нотолсон.

Дэлхий дахины цар тахлын эрсдэлийн амаргүй жил хагасыг оруулж тооцоод чамлахааргүй ажлыг гадаад харилцааны салбарт амжуулжээ. 2017-2021 онд 5 дахь Ерөнхийлөгчийн өнгөн дээр гадаадад хийх айлчлал, гадаадаас хүлээж авах дээд өндөр хэмжээний

төлөөлөгчдийн тоо харьцангуй бага гарч байна. Тэрээр гадаадад айлчилсан байдал нь ингэж жагсана. Үүнд 2017 онд Жүдо бөхийн насанд хүрэгчдийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн (Унгар, Будапешт), Дорнын эдийн засгийн III чуулга уулзалт (Владивосток); 2018 онд ШХАБ-ын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн XVIII хуралдаан (Циндао, БНХАУ), Дорнын эдийн засгийн IV чуулга уулзалт (Владивосток), Жүдо бөхийн насанд хүрэгчдийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн (Азербайжан, Баку), АСЕМ-ын дээд хэмжээний XII уулзалт (Брюссель), Дэлхийн хөрөнгө оруулалтын чуулга уулзалт (Женев); 2019 онд БНХАУ-д айлчлал, “Нэг бүс, нэг зам” олон улсын хамтын ажиллагааны форумын II уулзалт (Бээжин), Киргизстанд айлчлал, ШХАБ-ын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн XIX хуралдаан (Бишкек, Киргизстан), АНУ-д айлчлал, Дорнын эдийн засгийн V чуулга уулзалт (Владивосток), БНЭУ-д айлчлал; 2020 онд Давос хотноо Дэлхийн эдийн засгийн 50 дугаар чуулга уулзалт, Норвегийн



Хаант Улсад айлчлал, БНХАУ-д айлчлал (коронавирусийн эсрэг “Гучин мянган хонины дипломат” санаачилга) гэсэн жагсаалт гарч байна. Хариуд нь гадаадаас урьж айлчлуулсан нь ганцхан буюу ОХУ-ын Ерөнхийлөгчийг 2019 онд урьж айлчлуулсан дүнтэй байв.

Түүний хэлсэн үгс байна. Олон жил яриа хэлцлийн түвшинд өрнөсөн гурван улсын хамтын ажиллагаанаас бодит үр дүн, хэрэгжилтийг Монголын ард түмэн хүлээж байгаа. Тийм учраас бодит хэрэгжилтийн төлөө миний бие эрхэм Ши Жиньпин дарга, эрхэм В.В.Путин Ерөнхийлөгч нартай ойр дотно, идэвхтэй хамтран ажиллах эрмэлзэл дүүрэн байна. Энэ зорилтын төлөө байнгын холбоотой, хугацаатай, уялдаатай ажиллах хатуу үүргийг гурван улсын холбогдох байгууллагуудад өгч, шуурхай хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллахыг санал болгож байна<sup>7</sup> хэмээн тэрээр 2018 онд ярьж байсан.

Монгол-Оросын хоорондын худалдаа-эдийн засгийн харилцаанд эргэлт гаргахын үндсийн үндэс нь улс төрийн итгэлцэл гэдэг дээр ноён Х.Баттулга бат зогсож байв. Үүндээ хүрэх бүх гарц хувилбарыг тэрээр эрэлхийлж ажилласан. ОХУ-тай стратегийн иж бүрэн түншлэлээ 2019 онд Ерөнхийлөгч В.Путины айлчлалын үеэр Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай гэрээгээр гарын үсэг зурж баталгаажууллаа. Монгол-Оросын харилцаанд Владивостокт зохиогддог Дорнын эдийн засгийн форум онцгой

ач холбогдолтой хэмээн үзсэн нь 5 дахь Ерөнхийлөгчийн гадаад бодлогын нэг онцлог байв.

Эрчимтэй хөгжиж байгаа бүс нутаг, хоёр хөршийнхөө дунд бид арал шиг үлдэж болохгүй хэмээн ноён Х.Баттулга үздэг, тэр хэрээрээ хоёр хөрштэй явуулах бодлогоо олж харахыг хичээсэн. 2019 онд БНХАУ-д төрийн айлчлал хийсний сацуу “Нэг бүс–Нэг зам” олон улсын хамтын ажиллагааны дээд хэмжээний II форумд оролцсон. Энэхүү айлчлал нь Монгол-Хятадын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ой тэмдэглэх үед тохиосноороо бүр ч онцлог үйл явдал болжээ. Мөн “Нэг бүс–Нэг зам” санаачилгын бүтээн байгуулалтад Монголын талын илүү гүн гүнзгий, бүх талын оролцоог нэмэгдүүлэх боломж, сэтгэл зүйн бэлтгэлийг Ерөнхийлөгч Х.Баттулга бодолцсон.

2019 оны айлчлалын үеэр БНХАУ-ын дарга Ши Жиньпин Монгол Улсын Ерөнхийлөгчид хандан хоёр орны иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг иж бүрэн утгаар шинэчилж, худалдааны эргэлтийг 2020 он гэхэд 10 тэрбум ам.долларт хүргэх, төмөр зам барих, боловсруулах үйлдвэрлэл хөгжүүлэх, бүс нутгийн энх тайван аюулгүй байдал гэх мэт олон чиглэлээр хамтран ажиллахдаа бэлэн байгаагаар илэрхийлсний хамт Монголын зүгээс дэвшүүлсэн ажил эрэгч саналуудыг хамтран хэрэгжүүлэхийн төлөө дэмжиж ажиллахаа мэдэгдсэн<sup>8</sup>.

<sup>7</sup> Ерөнхийлөгч Х.Баттулга: Олон жил яриа хэлцлийн түвшинд өрнөсөн ажлыг бодит болгохын төлөө Ши Жиньпин дарга, В.В.Путин Ерөнхийлөгч нартай ойр дотно, идэвхтэй хамтран ажиллах эрмэлзэл дүүрэн байна, *sonin.mn* agency, 2018-06-09

<sup>8</sup> Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга БНХАУ-ын дарга Ши Жиньпintэй уулзлаа, [president.mn/5238/](http://president.mn/5238/)

Тэрээр 2019, 2020 онд БНХАУ-д айлчилж, дээд өндөр түвшний айлчлалын давтамжийг илтгэж, “Гучин мянган хонь”-ны дипломат ажиллагаагаараа харилцаанд цоо шинэ эрүүл уур амьсгал оруулав.

Энд зориуд тэмдэглэхэд, гуравдагч хөрштэй тогтоосон харилцааны түүхэнд Монгол-Америк, Монгол-Япон, Монгол-Энэтхэгийн стратегийн түншлэлийн харилцаа ноён Х.Баттулгын өнгөн дээр ил тодоор бичигдэн үлдэж байна. Монгол Улсын гадаад бодлогын нэн чухал тулгуур болох өрнө, дорнын тэргүүлэх чиглэлийн улсуудтай найрсаг харилцаа хөгжүүлж, тэдгээрийн эдийн засгийн болон бусад бодит сонирхлыг Монголд бий болгох зорилт 2018-2019 онд амжилттай хэрэгжлээ. АНУ-тай стратегийн түншлэл тогтоохоор ажилласан, Өргөтгөсөн иж бүрэн түншлэлийн харилцааг АНУ-тай 2018 онд тунхагласнаа жил хүрэлгүйгээр 2019 оны зун Стратегийн түншлэлээ зарлаж чадлаа. Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн АНУ-д 2018 оны намар хийсэн албан ёсны айлчлалын тухай Хамтарсан мэдэгдэлд АНУ-ыг “чухал гуравдагч хөрш”, “дотнын анд”, “чухал түнш орон”<sup>9</sup> хэмээн бүр нэрлэсэн байгаа нь улс төрийн гүн агуулга бүхий дүгнэлт гэж ойлговол зохилтой.

АНУ-тай харилцааны түвшин ямар хэмжээнд хүрснийг илтгэх эшлэл авъя. Ноён Х.Баттулгатай хамтран ажилласан, тухайн үеийн Гадаад харилцааны сайд ярьжээ. ГХЯ-ны өнгөрсөн 4 жилийн үр дүнтэй ажлуудын эхэнд Монгол Улс АНУ-тай стратегийн харилцаатай болж чадсаныг

ийнхүү илэрхийлжээ: –Харилцааны томьёоллууд 10-аас доошгүй жилд нэг удаа өөрчлөгддөг. Ер нь тийм ч амар өөрчлөгдөөд байдаггүй. Харин бид 2018 онд АНУ-тай иж бүрэн түншлэлээс өргөтгөсөн иж бүрэн түншлэлийн харилцаа руу шилжиж, дараа жил нь стратегийн түншлэлийн харилцаанд шилжсэн. Энэ бол байж болох хамгийн дээд түвшний харилцаанд хүрч байгаа нь тэр. Монгол Улс НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын 5 гишүүн орны гуравтай нь стратегийн түншлэлийн харилцаатай болсон. Өөрөөр хэлбэл, манай стратегийн түншлэгч орнуудын тоонд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн олонх орж ирж байна гэсэн үг. Энэ бүгд манай улсын гадаад бодлого, гадаад харилцаа, аюулгүй байдалд тун чухал нөлөөтэй. Монгол Улсын бүс нутагтаа эзлэх жин байр суурь бэхжиж, дараа дараагийн хамтын ажиллагааны төслүүдийг хэрэгжүүлэхэд маш том түлхэц болдог. Бид АНУ-тай Мянганы сорилтын сангийн 350 сая ам.долларын буцалтгүй тусламжийн төсөл хэрэгжүүлж байна. Манай ноос, ноолууран бүтээгдэхүүнийг дэмжсэн гуравдагч хөршийн хууль Конгресст өргөн баригдсан. АНУ-ийн Конгресст хууль өргөн баригдана гэдэг нь өөрөө маш нарийн процесс, тийм амар ажил биш. Өргөн баригдаад, хэлэлцэгдээд эхэлнэ гэдэг маш том алхам болж байна Тэнд олон улстөрч дэмжиж байгааг илэрхийлж байгаа хэрэг. Энэ хуулийг өргөн барихад Конгрессын гишүүд нам үл харгалзан дэмжсэн. Бүхий л зүйл дээр хоёр тал болж, ширүүн өрсөлддөг тэднийг энэ хуулийг дуу нэгтэй дэмжиж

<sup>9</sup> Өргөтгөсөн иж бүрэн түншлэлийн тухай Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын Хамтарсан мэдэгдэл, *mfa.gov.mn*, 2018-09-21

байгааг гайхаж байгаагаа америкчууд хэлж байсан шүү. Гуравдагч хөршийн хууль батлагдвал манай ноос, ноолуурын зах зээл тэлж, экспортод эерэг нөлөө үзүүлнэ<sup>10</sup> гэжээ.

АНУ “чухал гуравдагч хөрш” гэдгээ нотолсон алхам бол **тус улсын** Конгрессын Төлөөлөгчдийн танхим Монгол-Америкийн стратегийн түншлэлийг бэхжүүлэх тухай тогтоол<sup>11</sup> 2020 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа баталсан явдал байв. Тогтоолд Монголын ардчилал, өөрчлөлт шинэчлэлийн ололтууд, Монгол, Америкийн харилцаа, хамтын ажиллагааны амжилтууд, тухайлбал хоёр улс 2019 онд стратегийн түншлэлийн харилцаа тогтоосон, хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх Замын зураглалыг тохиролцсон, МСК-ын Хоёрдугаар компакт гэрээ, Ил тод байдлын хэлэлцээр, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа зэргийг онцолжээ.

Японтой XXI зууны “Иж бүрэн түншлэл”-ийн харилцааг урагшлуулах чиглэлээр ажилласаар, анхлан 2010 онд үндсэн зорилгоосоо давж Стратегийн түншлэлд хүрсэн бол 2018 онд уг түншлэлийг бүхий л салбарт бэхжүүлэх зориг эрмэлзлээ нотолсон “Монгол Улс, Япон Улсын Стратегийн түншлэлийг улам бүр бэхжүүлэх тухай хамтарсан мэдэгдэл”<sup>12</sup> гаргав. Монгол Улсын “гуравдагч хөрш” улсууд дотроос нэн тэргүүнд “Стратегийн түншлэл”-ийн харилцаа тогтоосон

чухал түнш Японтой харилцаа, хамтын ажиллагаагаа улам бүр гүнзгийрүүлэн хөгжүүлэх нь ноён Х.Баттулгын төр толгойлсон 4 жилийн гадаад бодлогын нэг онцлог байв. “Чөлөөт, нээлттэй Энэтхэг, Номхон далай”-г цогцлоохоор ажиллаж байгаа Японы үйл ажиллагааг Монголын тал дэмжсэнээ илэрхийлэв. Монгол, Японы улстөрийн дээд түвшний айлчлал, яриа хэлэлцээний давтамжийг хадгалах нь бүү хэл улам ойртуулах чиглэлээр ажиллаж, Ерөнхийлөгч Х.Баттулга, Ерөнхий сайд Ш.Абэ нар дээд хэмжээнд тогтмол уулзаж байв. Ерөнхий сайд ч хоёр дараалан Японд айлчилж. Японы Гадаад хэргийн сайд мөн хоёр дараалан Монголд айлчилжээ.

*Ер нь 2019 он ноён Х.Баттулгын гадаад бодлогын оргил жил байсныг энд тэмдэглэх хэрэгтэй. Иж бүрэн стратегийн ба стратегийн түншлэл бүхий 5 гүрэнтэй (ОХУ, БНХАУ, АНУ, Япон, Энэтхэг) тэнцвэрийг барьсан, аль алинтай нь харилцааны далайцыг нэмэгдүүлсэн айлчлалуудыг амжилттай зохион байгуулжээ.*

Ноён Х.Баттулга гадаад бодлогоо маш өвөрмөц арга барилаар (заримдаа стандарт бус) явуулсан гэж үзэж болно. Тэрээр гурван салбарт амьдралаа зориулсан бие хүний хувьд гадаад бодлогыг тэгж харсан. Уран зураач, самбо бөхийн дэлхийн аварга-тамирчин, бас бизнесч. Уран зургийн урлагийн нүдээр гадаад бодлогыг харахыг хичээсэн, бизнесийн гүйлгэн ухаан, дээр нь тамирчны хурд, тэвчээр,

<sup>10</sup> Д.Цогтбаатар: Том эрх ашгийг сөрснөөрөө би олон дайсантай болж байгаа, [ikon.mn/](http://ikon.mn/)

<sup>11</sup> АНУ-ын Конгресс Монгол, Америкийн харилцааг бэхжүүлэх тухай тогтоол батлав, [mfa.gov.mn/](http://mfa.gov.mn/) 2020.12.08

<sup>12</sup> Монгол, Японы Стратегийн түншлэлийг бэхжүүлэх мэдэгдэл гаргалаа, [news.mn/r/2059581/](http://news.mn/r/2059581/); Монгол Улс, Монгол Улс, Япон Улсын стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг танилцуулав, [mfa.gov.mn/](http://mfa.gov.mn/) 2018.12.14

аль алин нь хослоод ирэхлээрээ маш прагматик, хувьсаж чаддаг, маневрлаж чаддаг гадаад бодлого харагдсан гэж

хэлж болно. Хэрэв ковидын цар тахал тулгараагүй бол илүү ихийг ч бүтээчих байсан болов уу.

### Тав. Гадаад бодлогын шилжилт ба шинэчлэл (2021 оноос)

Ноён У.Хүрэлсүх Монгол Төрийг тэргүүлээд хоёр жил хагасыг үдэж байна. Хэрэв төрт улсын түүхээр авч үзвэл ахархан хугацаа. Харин энэ цаг үеийн өнцгөөс, хурдтай XXI зууны шинэ эриний дэвсгэр дээр авч яривал хоёр жил хагас гэдэг ихээхэн ажил амжуулж, амжилтад хүрчихсэн байх хугацаа юм. Түүхэн уламжлал ба орчин цагийн хослол дээр энэхүү хоёр жил хагасыг дүгнэе.

Монгол Төр ковидын жил хагасын нөхцөлд гадаад харилцаагаа үлэмж хумиад байсныг аажмаар тэлэх, гадаад харилцааг идэвхжүүлэхэд анхаарч ажилласан. Гадаад харилцааны үр өгөөж, онч, санаачилга авах тал руу түлхүү анхаарсан.

Монгол Төрийн тэргүүнүүдийн гадаад бодлогыг авч үзэхэд өмнөх Ерөнхийлөгч нар (тухайлбал Н.Багабанди, Ц.Элбэгдорж нар) гадаад айлчлалуудыг тултал хэрэгжүүлж, ихээхэн идэвх зүтгэл гаргаж байсныг ноён У.Хүрэлсүх илүү оновчтой болгох, үр дүн гарахгүй, эсвэл хожим үр дүн гарах айлчлалуудаас түр татгалзах, чухам ямар зорилгоор айлчлах, юунд хүрэх, тэр нь монголын ард түмэнд ач тусаа өгөх, нэг үгээр бол үр дүнг нь голчлон авч үзсэн нь шинэлэг үзэгдэл байлаа. Хэлбэр биш агуулга, ёслол биш бодит ажил, нэр хүнд биш гарт баригдах үр дүн гэдэг дээр түлхүү анхаарч байна.

2021 онд тэрээр үүрэг тажилдаа ороод гадаад айлчлалуудаа төлөвлөхдөө аль

нэг гадаад хөрш түнш улсыг сонголтгүй НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 76 дугаар чуулганд оролцохоос гадаад айлчлалаа эхлүүлсэн. Өмнөх Ерөнхийлөгч нарын үед аль нэг гадаад түнш улс сонгож айлчлахад бусад түнш улсын (ялангуяа хоёр хөрш) зүгээс эмзэглэх явдал гардаг байсныг зөв тооцоолсон. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 76 дугаар чуулганы дараа ч энэ зарчмаа барьсан. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн удирдагчдын дээд түвшний уулзалтад (Глазго, Их Британи) оролцож, дэлхий нийтийн өмнө тулгарсан нийтлэг асуудал шийдэхэд бэлэн байгаагаа илэрхийлсэн ба энэ төрлийн уулзалтад өндөр ач холбогдол өгч байгаагаа ч дараагийн хоёр жилд нь (Египет, АНЭУ-д) нотолсон.

Монгол Улсын зургаа дахь Ерөнхийлөгчийн хувьд гадаад улс төрийн айлчлалаа 2021 оны 12 дугаар сард ОХУ-аас эхэлсэн. Энэ бол 2019 онд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины Монголд хийсэн айлчлалын хариу айлчлал, Монгол-Оросын хооронд Иж бүрэн стратегийн түншлэл тогтоосны дараах анхны айлчлал, бас Монгол-Оросын зуун дамжсан найрсаг харилцааны түүхт 100 жилийн ойн арга хэмжээний хаалтыг хийсэн айлчлал байсан гэдгээрээ түүхэн ач холбогдолтой юм.

2022 онд Ерөнхийлөгч У.Хүрэлсүх гадаад айлчлалууд руу төдийлөн шимтээгүй, харин айлчлалыг хоёр

урсгалтай болгох, юуны өмнө НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргыг эх орондоо айлчлуулах, мөн олон талт дипломат бодлогоо үргэлжлүүлэн урагшлуулах, тэр хүрээнд хоёр талын болон гурван талын харилцаагаа хөгжүүлэхэд анхаарсан. Узбекистаны Самарканд хотноо ШХАБ-ын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн XXII хуралдаанд ажиглагч гишүүн Монгол Улсын Ерөнхийлөгчийн хувьд оролцохдоо хоёр хөрш орны удирдагчидтай уулзаж, мөн цар тахлын улмаас хоёр жил завсарласан Монгол-Орос-Хятадын Төрийн тэргүүн нарын гурван талт ээлжит VI уулзалтад оролцож, стратегийн ач холбогдолтой “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”, “Транзит Монгол” бодлогоо таниулж, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан ОХУ-аас БНХАУ-д байгалийн хий нийлүүлэх хоолойн төслийн хэрэгжилтийн талаар ярилцаж, хамгийн чухал нь тийм хийг БНХАУ хүлээн авахад бэлэн байна гэсэн үгийг Хятадын удирдагчаар зөвшөөрүүлсэн нь онц ач холбогдолтой болсон билээ.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 77 ба 78 дугаар хоёр чуулганд оролцсон тухайд базаж томьёолоход, дайн, геополитикийн хурц зөрчил тэмцэлтэй, эсрэгцсэн, хуваагдсан энэ ертөнцөд энх амгалан хэрэгтэй байна, түүний төлөө тэмцэх хэрэгтэй гэсэн утгаар У.Хүрэлсүх даян дэлхийн энх тайвныг уриалж үг хэлсэн. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гуттеришийн Монголд айлчлахдаа бидэнд оноосон “Энх тайвны бэлгэ тэмдэг Монгол Улс” гэдэг бол зүгээр нэг нэрлэсэн биш, цаанаа гүн утга агуулгатай, тэр

хэрээрээ үнэ цэнтэй, онцлогтой гэдэг утгаар Төрийн тэргүүн тэгж хэлсэн болов уу. Монгол бол даян дэлхийн энх тайванд санаа тавьдаг, түүний төлөө зовж шаналдаг, тэр хэрээрээ энх тайвны санал санаачилга дэвшүүлдэг гэдгийн илэрхийлэл гэж үзэхээр, даян дэлхийг хамарсан бүхий л асуудалд манай улс ямар байр суурь баримталж байна вэ гэдэгт иж бүрэн хариулт өгөхийг хичээсэн, бүгдийг хамруулсан өргөн дэлгэр үг байв. Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, олон тулгуурт, бие даасан гадаад бодлогыг тууштай явуулж ирсэн, цаашдаа ч тэгнэ гэсэн итгэлээ дахин нотолсон нь тэр байв.

Ноён У.Хүрэлсүх уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх, дэлхийн дулаарлыг сааруулах чиглэлээр Монгол Улсын баримталж буй байр суурийг илэрхийлж, үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг танилцуулж, “Тэрбум мод” хөтөлбөрөө сурталчилсан. Мөн зарим улсын төрийн тэргүүн болон олон улсын байгууллагуудын удирдлагуудтай хоёр талын уулзалтууд хийсэн.

2022 оны хувьд Төрийн тэргүүний гадаад айлчлалуудын оргил нь оны төгсгөл хавьд хэрэгжүүлсэн БНХАУ, Японд хийсэн Төрийн айлчлал байв. Цаг үеэ олсон, хоёр хөрш ба гуравдагч хөршүүдийн хоорондын тэнцвэр хангасан, зээл тусламжийн агуулгатай явж ирсэн харилцааг харилцан нөхсөн, худалдаа-хөрөнгө оруулалтын, мөн монгол хүний хөгжлийн агуулгатай болгосон хоёр айлчлал хэмээн үзэж болно.

2022, 2023 оны хувьд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нар хоёулаа БНХАУ-д айлчилсан, БНХАУ-ын хууль тогтоох

дээд байгууллагын дарга, Гадаад хэргийн сайд (Төрийн Зөвлөлийн гишүүн) манай эх орныг зориод ирсэн, ялангуяа Төрийн тэргүүний албан ёсны төрийн айлчлал угтуулаад цахимаар салбар салбарын сайд нар хамтран хуралдаж, хэлэлцэх, гарын үсэг зурах бүх асуудал, баримт бичгээ харилцан тохиролцсон тохиолдол тэр болгон давтагдаад байдаггүй. Дэлхийг зогсонги байдалд оруулсан цар тахлын хоёр жилийн дараа, БНХАУ-ын дотоод амаргүй улс төрийн үйл явцын дараа, ХКН-ын ХХ их хурлын дараа манай Ерөнхийлөгч айлчилсан нь хоёр талдаа улс төрийн өндөр ач холбогдолтой үйл явдал байв. Хоёр тал Төрийн энэ айлчлалд хоёулаа маш их ач холбогдол өгсөн. Тэгэх тусмаа хоёр сар хагасын дотор хоёр Төрийн тэргүүн албан ёсоор хоёр удаа уулзсан, хоёр улсын хооронд бусдад жишиг болох үлгэр жишээ харилцаа болгохын төлөө хоёул нэгэн санаагаар тэмцсэн, иж бүрэн стратегийн түншлэлээ шинэ шатанд гаргасан, манай улсад ашигтай байдлаар худалдаа-эдийн засгийн харилцаа хөгжиж байгаа гэдгээр “2022 он” түүхэнд нэн чухлаар тэмдэглэгдэнэ. Жагсаавал олон салбар буй, худалдаа-эдийн засаг, эрчим хүчний хамтын ажиллагаа, нүүрсний худалдаа, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн бүтээн байгуулалтууд гээд яривал баярлуулах мэдээ **(Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг шинэ эрин үед урагшлуулан хөгжүүлэх тухай Монгол Улс, БНХАУ-ын Хамтарсан мэдэгдлээс харна уу)** олонтой буцаж ирсэн. Манай улсын зорилго нь Хятадтай нүүрсний урт хугацааны хамтын ажиллагаа явуулах ба жилдээ

40-70 сая тонныг Хятадад худалдана гэдэг дээр манай тал зогссон. 2019 онд түүхэндээ хамгийн их буюу 31 сая тонныг экспортолж байсан бол 2-3 дахин өсгөхөөр Төрийн айлчлалаар хоёр Төрийн тэргүүн ярьж тохиролцжээ. Гэтэл 2023 оны байдлаар энэ үзүүлэлт хэдийнээ давжээ. Хоёр орны худалдаа ч шинэ шатанд гарч эхэлж байна.

2023 оны намар тохиосон хоёр үйл явдал дипломатын түүхэнд өвөрмөц байр суурь эзэлнэ. Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Бээжинд “Нэг бүс, нэг зам” олон улсын хамтын ажиллагааны дээд түвшний чуулга уулзалтад уригдан оролцохдоо БНХАУ-ын дарга Ши Жиньпинтэй уулзсан бол 7 хоногийн дараа Киргизийн Бишкек хотноо Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ ШХАБ-ын Засгийн гарын тэргүүн нарын зөвлөлийн хуралд оролцохдоо БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Чянтай уулзаж, хоёр талын харилцааны асуудлаа ярилцжээ. Мөн Бээжинд “Нэг бүс, нэг зам” дээд түвшний чуулга уулзалтын хоёр зочин У.Хүрэлсүх, Владимир Путин нар уулзсан бол 7 хоногийн дараа Киргизийн Бишкек хотноо Монгол, Оросын хоёр Ерөнхий сайд нар уулзсан нь цаг хугацааны хувьд сонин давхцал, агуулгын хувьд хоёр талын харилцааны, тэр дундаа гурвалсан харилцааны нэг чухал арга хэмжээ болжээ.

2022 оны төгсгөл хавьд Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Япон Улсад айлчилсан нь Монгол-Японы харилцааны түүхэн тод үсгээр тэмдэглэгдэх айлчлал болжээ. “Монгол Улс, Япон Улсын энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-ийг хөгжүүлэхэд чиглэсэн Хамтарсан мэдэгдэл гаргасан.

Стратегийн түншлэлийн дараагийн дээд шат нь “иж бүрэн” гэх тодотголтой байх учиртай бол, бид хамтдаа “алтан дундаж”-ийг олоод “тусгай” гэсэн тодотгол хийсэн. Хоёр хөршдөө хар суулгахгүй, гэхдээ Монгол Улсын гадаад бодлогод гурвуулаа нэг зиндаанд гэж ойлгогдохоор “алтан дундаж”-ийг

зөв томъёолсон.

2023 оны хувьд ноён У.Хүрэлсүхийн түвшинд Монгол-Францын харилцаа цоо шинэ түүхэн үе шатанд гарч, БНПУ-ын Ерөнхийлөгч Монголд айлчилж, Ерөнхийлөгч өөрөө Азийн чиглэлд томхон алхам хийж Вьетнам, Лаост Төрийн айлчлал хийгээд байна.

### Зургаа. Зарим дүгнэлт

Төгсгөх үгс. Миний бие Элчин сайд байсны хувьд, одоо гадаад бодлогын эксперт байгаагийн хувьд Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн 6 удаагийн айлчлал, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн гурван удаагийн айлчлалд хамт оролцож дагалдан явлаа. Миний дээр томъёолсон “Хэлбэр биш агуулга, ёслол биш бодит ажил, нэр хүнд биш гарт баригдах үр дүн” гэдэгтээ ихээхэн ач холбогдол өгдөг, ажлыг шуурхай амжуулдаг, шуурхай шийддэг, түс тас, ил тод, дайчин чанар ноён У.Хүрэлсүх, Л.Оюун-Эрдэнэ нарт харагдаж байсныг тэмдэглэх нь зөв болов уу.

Сүүлийн хоёр жилд гуравдагч хөршийн бодлого амжилттай хэрэгжиж байгааг зориуд тэмдэглэе. Монгол Улс эдийн засгаа сэргээх бодлогын хүрээнд хоёр хөршөөс гадна гуравдагч хөршийн оролцоог нэмэгдүүлж, эдийн засгаа төрөлжүүлэх, олон тулгуурт тогтвортой бүтцийг бий болгохоор зорин ажиллаж байна. Гэхдээ уламжлалт хоёр хөршөөсөө нүүр буруулах гээгүй. Бас үргэлж хамааралтай байгаад байна гэсэн үг биш. Тэр хоёроос гадна “Гуравдагч хөрш”-ийн оролцоог нэмэгдүүлж, эдийн засгаа төрөлжүүлэх, олон тулгуурт, зохистой бүтэц бий болгох нь туурга

тусгаар Монгол Улсын маань бүрэн эрхийн асуудал юм.

Хөрөнгө оруулалтын бодлогоо улам тодорхой болгож, тогтвортой, тууштай, “Итгэлтэй, найдвартай, удаан хугацааны түнш байх” зарчим баримтлан, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах чиглэлээр цогц шинэчлэл хийж эхэлж байна.

Стратегийн маш чухал салбарт хамтран ажиллахад бэлхэн байна гэдгээ 2023 онд Франц, Польш, АНУ-д (Ерөнхий сайдын айлчлал) нотолж харуулсан нь Монгол Улсын гадаад бодлогын нэг ёсны ялалт байлаа. 2023 оны хувьд Ромын Пап бөгөөд Гэгээн ширээт улсын Төрийн тэргүүн анх удаагаа Монгол Улсад айлчилсныг улс төр-стратегийн онцгой ач холбогдолтой үйл явдал хэмээн үзэж байна. Папын айлчлал гуравдагч хөршийн бодлогын үр дүнг тодоор илтгэх чухал ач холбогдолтой боллоо<sup>13</sup> хэмээн Гадаад харилцааны сайд дүгнэсэн. Пап Францис айлчлалынхаа үеэр манай улсын ард иргэд, олон нийтэд хандаж үг хэлэхдээ манай улсын өнө эртний түүх, соёл, уламжлалын утга агуулга, мөн чанарыг онцолж, дэлхий нийтийн

<sup>13</sup> <https://www.24tsag.mn/a/219990>

энх тайван, тогтвортой хөгжилд оруулж буй манай улсын хувь нэмрийг сайшаасан. Тэрбээр хэлэхдээ “Өргөн хүрээний дипломат харилцаатай, Нэгдсэн Үндэстний Байгууллагын идэвхтэй гишүүн Монгол Улс өнөөдөр хүний эрхийг дээдлэх, энх тайвныг цогцлоохын төлөө хүчин чармайлтаараа Ази тивийн цээжнээ төдийгүй олон улсын тавцанд чухал үүрэг гүйцэтгэж байна” гэдгийг тодотгож, “Оюун санаа, сүсэг бишрэлийн торгон мэдрэмж монголын соёлын мөн чанарын эд эс бүхэнд гүн гүнзгий оршдог учраас Монгол Улс шашин шүтлэгийн эрх чөлөөний бэлгэ тэмдэг байх нь аргагүй юм”<sup>14</sup> гэж сайд тэмдэглэсэн билээ.

Папын айлчлалыг гадаад улс орнуудын 150 орчим хэвлэл мэдээллийн төлөөлөл сурвалжилсан. Тиймээс Монгол Улс энэ өдрүүдэд дэлхийн олон улс орнууд төдийгүй 1.3 тэрбум католик сүсэгтнүүдийн анхаарлын төвд байсан нь манай орны хувьд эх орноо дэлхийд таниулсан гадаад сурталчилгаа, ардын дипломатын томхон алхам болсон билээ. Миний бие гадаад бодлого судлаачийн хувьд “Түүхэн, Төрийн, үл давтагдах айлчлал” хэмээн дүгнэсэн ярилцлагууд хэд хэдэн ТВ, сайтуудад өгсөн болно.

Эцэст нь дүгнэж үзэхэд, Монгол Улсын гадаад бодлого бол маш амжилттай яваа салбар юм. Гадаад бодлогын бүх чиглэлд тэнцвэрийг

маш сайн хадгалж барьж байгаагийн илэрхийлэл болсон маш олон айлчлалуудыг энд бүгдийг нэр заан дурдах албагүй. Тэнцвэр хадгална гэдгийг юу гэж ойлгож байна гэхлээр хоёр хөрш болон гуравдагч хөршийн харилцаа тэнцвэржсэн, хоёр хөршийн харилцаа бас хоорондоо тэнцвэртэй байна, мөн олон талт хамтын ажиллагаа маань хоёр талын харилцааны сүүдэрт орчхоогүй урагшилсаар байна хэмээн би хэргээр тодотгож хэлж байна.

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ ингэж тэмдэглэсэн байдаг. “Монгол Улс далайд гарцгүй, засаглалын ялгаа бүхий хоёр хөрштэй боловч ардчилал, хүний эрх, шашны эрх чөлөөг дээдэлдэг ардчилсан орон бөгөөд манай гадаад бодлогын цөм бол даян дэлхийн энх тайван юм. Монгол Улсад хийж буй таны төрийн айлчлал даян дэлхийн энх тайван, амар амгаланг цогцлоох нийтлэг зорилтыг биелүүлэхэд онцгой хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна”<sup>15</sup> гэжээ. Энэ нь дэлхий нийтийн болон бүс нутгийн чанартай бүх асуудлаар зөвхөн хоёр их хөрштэйгөө байр суурь бодлого яв цав нийцэх албагүй, Монгол Улс үндэсний эрх ашгаа дээдэлнэ, ард түмнийхээ сонголтыг хүндэтгэнэ, гэхдээ гадаад бодлого нь энхийг эрхэмлэсэн, идэвхтэй, олон тулгууртай байна гэсэн үг ажгуу.

<sup>14</sup> <https://www.isec.mn/index.php/n/54415>

<sup>15</sup> Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Гэгээн Ширээт Улсын Төрийн тэргүүн Пап Францист бараалхав, <https://montsame.mn/mn/read/325816>



## Mongolia's foreign policy reform

**Bayarkhuu Dashdorj**

*Foreign policy expert, Ambassador Extraordinary and Plenipotentiary  
Ulaanbaatar, Mongolia  
bayardevi@hotmail.com*

**Abstract:** *The historical topic of how Mongolia's foreign policy has evolved in 33 years of democracy and reform, along with the results achieved, was discussed against the background of the actions of all six Presidents of Mongolia. Our successive Presidents and Governments have maintained a continuity of independent, balanced, active, open, multi-pillared, and theoretically pragmatic foreign policy. During the time of the USSR, the People's Republic of Mongolia was effectively a satellite country, almost as the 16th Republic of the Soviet Union. After the end of the "Cold War," the new Mongolia sought and declared a new foreign policy, subsequently moving towards a "multi-pillar" foreign policy that engaged with many new partner countries, including China, the United States, Japan, and Western Europe. In just a year and a half, it has reached the present day by choosing and implementing a multi-pillar foreign policy that has strengthened its independence.*

**Keywords:** *Mongolia, foreign policy, multi-pillar, "third neighbour" policy, Russia, China*

<i>The date of submission:</i>	2023.12.25
<i>Completion of review:</i>	2024.01.04
<i>Final decision for acceptance:</i>	2024.01.08